

ГЭРЛЭЛТИЙГ ЦУЦЛАХ

Гучин нэгдүгээр зүйл

1. Гэрлэлтийг цуцлах тухай хэргийг шийдвэрлэхдээ хусэлтээ гаргах уед гэрлэгсдийг харьяалж байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийг хуулийг баримтална.

2. Хэрэв гэрлэгсдийн нэг нь Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн харьяат нөгөө нь Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн харьяат бол тэдний хэргийг авч хэлэлцэж байгаа шуух өөрийн улсын хуулийг баримтална.

Гучин хоёрдугаар зүйл

1. Гэрээний 31-р зүйлийн I дэх ангид заасан тохиолдолд гэрлэлтийг цуцлах тухай хэргийг хусэлтээ гаргах уед тэднийг харьяалж байсан Хэлэлцэн Тохирогч Этгээдийн шуух шийдвэрлэх эрхтэй. Хэрэв гэрлэлтээ цуцлуулах тухай хусэлт гаргах уедээ Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа бол тэрхуу Хэлэлцэн Тохирогч Этгээдийн шуух уг хэргийг шийдэх эрхтэй.

2. Гэрээний 31-р зүйлийн 2 дахь ангид заасан тохиолдолд гэрлэгсэд нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн шуух гэрлэлтийг цуцлах шийдвэр гаргах эрхтэй. Хэрэв гэрлэгсдийн нэг нь Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн нутаг дэвсгэрт нөгөө нь Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт оршин суугаа бол Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн шуух тэдний гэрлэлт цуилах асуудлыг шийдвэрлэх эрхтэй.

Гучин гуравдугаар зүйл

Гэрлэлтийг хучингуйд тооцох

Гэрлэлтийг хучингуйд / хууль ёсны биш/ тооцох тухай хэргийг шуухээр авч хэлэлцэхэд Гэрээний 31, 32-р зүйлийг баримтална.